



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/030/НА-СТА-ТШЗ

|  |   |
|--|---|
| <p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Дорнод аймаг</p> <p>2026 он</p> | <p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br/>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br/>Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нармандах<br/>Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК<br/>Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг<br/>Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026.02.25 № 292

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН БУЛГАН  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.МӨНГӨНЧИМЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

2125020297

### Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Булган сумын ЗДТГ нь 2025 онд 5 зорилтын хүрээнд 94 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг "Хангалттай" буюу 94.4 хувиар үнэлсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         |
|------------|---|-------------------------|-------------------------|
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>168,479,832.00</b>   | <b>204,925,212.00</b>   |
| <b>31</b>  | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>   | -                       | -                       |
| <b>33</b>  | <b>АВЛАГА</b>   | -                       | -                       |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 168,479,832.00          | 204,925,212.00          |
| <b>354</b> | <b>Хангамжийн материал</b>  | <b>44,696,908.00</b>    | <b>81,142,288.00</b>    |
| 35420      | Аж ахуйн материал   | 841,050.00              | 707,050.00              |
| 35470      | Бусад хангамжийн материал   | 43,855,858.00           | 80,435,238.00           |
| 35600      | Мал амьтад  | 123,782,924.00          | 123,782,924.00          |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>2,137,236,289.90</b> | <b>2,438,089,574.23</b> |
| <b>39</b>  | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 2,137,236,289.90        | 2,438,089,574.23        |
| <b>392</b> | <b>Биет хөрөнгө</b>   | 2,129,990,115.10        | 2,431,147,424.47        |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц  | 556,184,257.61          | 1,274,627,157.61        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл   | (46,672,817.77)         | (55,734,604.21)         |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл  | 280,254,934.00          | 226,254,934.00          |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл   | (115,948,564.00)        | (84,311,749.00)         |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 67,589,700.00           | 85,145,700.00           |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | (37,214,392.97)         | (42,865,723.34)         |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 49,544,236.00           | 49,093,276.00           |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | (36,976,411.42)         | (39,117,626.45)         |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 1,379,453,856.33        | 1,458,687,456.33        |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | (390,425,782.68)        | (505,610,996.47)        |
| 39216      | Дуусаагүй барилга, байгууламж   | 424,201,100.00          | 64,979,600.00           |
| <b>393</b> | <b>Биет бус хөрөнгө</b>   | 7,246,174.80            | 6,942,149.76            |
| 39301      | Програм хангамж   | 3,197,200.00            | 3,197,200.00            |
| 39302      | Хуримтлагдсан элэгдэл   | (1,722,625.20)          | (2,026,650.24)          |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө  | 5,771,600.00            | 5,771,600.00            |
| <b>3</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>2,305,716,121.90</b> | <b>2,643,014,786.23</b> |
| <b>4</b>   | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | -                       | <b>0.00</b>             |
| <b>41</b>  | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | -                       | 0.00                    |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>2,305,716,121.90</b> | <b>2,643,014,786.23</b> |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 2,305,716,121.90        | 2,643,014,786.23        |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 581,162,917.26          | 581,162,917.26          |
| 51101      | Өмч: - төрийн   | -                       | -                       |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | 1,616,287,121.93        | 1,953,585,786.26        |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | 789,969,778.86          | 1,616,287,121.93        |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  | 826,317,343.07          | 337,298,664.33          |
| 51230      | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс                                     |                         |                         |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 108,266,082.71          | 108,266,082.71          |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>2,305,716,121.90</b> | <b>2,643,014,786.23</b> |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх он                | Тайлант он              |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                              | <b>1,905,124,622.58</b> | <b>1,843,710,470.00</b> |
| <b>11</b>   | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>  | -                       | -                       |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | <b>931,459,685.00</b>   | <b>826,998,690.00</b>   |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                  | 931,459,685.00          | 826,998,690.00          |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                           | 566,000.00              | -                       |
| 120017      | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө                  | 908,306,065.00          | 826,998,690.00          |
| 120018      | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал                  | 22,587,620.00           |                         |
| <b>121</b>  | <b>Хөрөнгийн орлого</b>   | -                       | -                       |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                | <b>973,664,937.58</b>   | <b>1,016,711,780.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                      | -                       | -                       |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                  | 93,980,517.58           | 4,007,480.00            |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,000,000.00           |                         |

Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|             |  |                         |                         |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 64,330,517.58           | 4,007,480.00            |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 19,650,000.00           |                         |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | <b>879,684,420.00</b>   | <b>1,012,704,300.00</b> |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт   | 879,684,420.00          | 1,012,704,300.00        |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>1,118,870,421.38</b> | <b>1,147,190,305.67</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>1,087,472,941.38</b> | <b>1,078,865,005.67</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>984,947,739.28</b>   | <b>1,034,512,082.10</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | <b>604,018,364.68</b>   | <b>713,418,429.87</b>   |
| 210101      | Үндсэн цалин   | 367,544,330.68          | 405,479,900.96          |
| 210102      | Нэмэгдэл   | 199,881,122.00          | 262,769,356.00          |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 5,496,055.00            | 5,085,000.00            |
| 210104      | Урамшуулал   | 31,096,857.00           | 40,084,172.91           |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | <b>77,517,641.87</b>    | <b>89,233,025.01</b>    |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 52,117,709.39           | 60,756,844.44           |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 5,775,008.52            | 6,820,399.03            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 5,088,158.92            | 4,604,940.43            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 1,408,300.18            | 2,882,999.02            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 13,128,464.86           | 14,167,842.09           |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | <b>10,725,139.35</b>    | <b>10,233,888.55</b>    |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 4,095,883.35            | 4,337,773.55            |
| 210302      | Түлш, халаалт  | 6,029,256.00            | 5,446,115.00            |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 600,000.00              | 450,000.00              |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | <b>43,299,107.00</b>    | <b>24,936,950.00</b>    |
| 210401      | Бичиг хэрэг  | 7,400,000.00            | 5,856,600.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 28,935,437.00           | 10,794,830.00           |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 1,042,800.00            | 1,075,900.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | 626,400.00              | 800,000.00              |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 2,200,000.00            | 2,000,000.00            |
| 210407      | Аж ахуйн материал худалдан авах зардал   |                         |                         |
| 210408      | Бараа материал акталсны зардал   | 3,094,470.00            | 4,409,620.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | <b>8,550,000.00</b>     | <b>5,899,900.00</b>     |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 2,550,000.00            |                         |
| 210604      | Урсгал засвар  | 6,000,000.00            | 5,899,900.00            |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>16,542,000.00</b>    | <b>11,060,000.00</b>    |
| 210702      | Дотоод албан томилолт  | 16,542,000.00           | 11,060,000.00           |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | <b>1,479,842.00</b>     | <b>1,208,483.00</b>     |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 880,000.00              | 515,383.00              |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 207,600.00              | 342,300.00              |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 126,851.00              | 209,200.00              |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 88,000.00               | 141,600.00              |
| 210807      | Газрын төлбөр  | 177,391.00              |                         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | <b>222,815,644.38</b>   | <b>178,521,405.67</b>   |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 79,491,630.58           | 5,627,500.00            |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | -                       | 5,200,000.00            |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол   | 143,324,013.80          | 167,693,905.67          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>102,525,202.10</b>   | <b>44,352,923.57</b>    |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>22,298,692.00</b>    | <b>-</b>                |
| 213208      | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг                      | 22,218,692.00           |                         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  | 80,000.00               | -                       |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>                                | <b>80,226,510.10</b>    | <b>44,352,923.57</b>    |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 80,226,510.10           | 44,352,923.57           |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>31,397,480.00</b>    | <b>68,325,300.00</b>    |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | <b>31,397,480.00</b>    | <b>68,325,300.00</b>    |
| 223001      | Бусад хөрөнгө  | 31,397,480.00           | 68,325,300.00           |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>  | <b>786,254,201.20</b>   | <b>696,520,164.33</b>   |
| <b>145</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>   | <b>-</b>                | <b>-</b>                |
| <b>225</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>7,936,858.13</b>     | <b>359,221,500.00</b>   |
| 225001      | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз   | 7,936,858.13            | 359,221,500.00          |
| <b>4</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>  | <b>(7,936,858.13)</b>   | <b>(359,221,500.00)</b> |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>   | <b>778,317,343.07</b>   | <b>337,298,664.33</b>   |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он              | Тайлант он              |
|-------------|--|-----------------------|-------------------------|
|             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>  |                       |                         |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>  | <b>974,230,937.58</b> | <b>1,016,711,780.00</b> |
| <b>11</b>   | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>   | -                     | -                       |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>566,000.00</b>     | -                       |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | 566,000.00            | -                       |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 566,000.00            | -                       |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 566,000.00            | -                       |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>973,664,937.58</b> | <b>1,016,711,780.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | -                     | -                       |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 93,980,517.58         | 4,007,480.00            |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | 10,000,000.00         |                         |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 64,330,517.58         | 4,007,480.00            |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 19,650,000.00         |                         |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | 879,684,420.00        | 1,012,704,300.00        |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 879,684,420.00        | 1,012,704,300.00        |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>   | <b>942,833,457.58</b> | <b>908,543,580.00</b>   |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>942,833,457.58</b> | <b>908,543,580.00</b>   |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>840,308,255.48</b> | <b>864,190,656.43</b>   |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | 604,018,364.68        | 713,418,429.87          |
| 210101      | Үндсэн цалин   | 367,544,330.68        | 405,479,900.96          |
| 210102      | Нэмэгдэл   | 199,881,122.00        | 262,769,356.00          |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 5,496,055.00          | 5,085,000.00            |
| 210104      | Урамшуулал   | 31,096,857.00         | 40,084,172.91           |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | 77,517,641.87         | 89,233,025.01           |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 52,117,709.39         | 60,756,844.44           |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 5,775,008.52          | 6,820,399.03            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 5,088,158.92          | 4,604,940.43            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 1,408,300.18          | 2,882,999.02            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 13,128,464.86         | 14,167,842.09           |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | 10,725,139.35         | 10,233,888.55           |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 4,095,883.35          | 4,337,773.55            |
| 210302      | Түлш, халаалт  | 6,029,256.00          | 5,446,115.00            |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 600,000.00            | 450,000.00              |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 40,204,637.00         | 20,939,430.00           |
| 210401      | Бичиг хэрэг  | 7,400,000.00          | 6,126,600.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 28,935,437.00         | 10,936,930.00           |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 1,042,800.00          | 1,075,900.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | 626,400.00            | 800,000.00              |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 2,200,000.00          | 2,000,000.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | 8,550,000.00          | 7,269,900.00            |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 2,550,000.00          | 770,000.00              |
| 210604      | Урсгал засвар  | 6,000,000.00          | 6,499,900.00            |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | 16,542,000.00         | 11,060,000.00           |
| 210702      | Дотоод албан томилолт  | 16,542,000.00         | 11,060,000.00           |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | 1,479,842.00          | 1,208,483.00            |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 880,000.00            | 515,383.00              |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 207,600.00            | 342,300.00              |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 126,851.00            | 209,200.00              |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 88,000.00             | 141,600.00              |
| 210807      | Газрын төлбөр  | 177,391.00            |                         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | 81,270,630.58         | 10,827,500.00           |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 81,270,630.58         | 5,627,500.00            |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | -                     | 5,200,000.00            |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>102,525,202.10</b> | <b>44,352,923.57</b>    |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 22,298,692.00         | -                       |

Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|             |   |                        |                         |
|-------------|---|------------------------|-------------------------|
| 213208      | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 22,218,692.00          |                         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал   | 80,000.00              | -                       |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>           | <b>80,226,510.10</b>   | <b>44,352,923.57</b>    |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 80,226,510.10          | 44,352,923.57           |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                               | <b>31,397,480.00</b>   | <b>108,168,200.00</b>   |
|             | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                              |                        |                         |
| <b>4</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>                                      | <b>-</b>               | <b>-</b>                |
| <b>5</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                                      | <b>31,397,480.00</b>   | <b>108,168,200.00</b>   |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>   | <b>31,397,480.00</b>   | <b>108,168,200.00</b>   |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>  | <b>31,397,480.00</b>   | <b>108,168,200.00</b>   |
| 223001      | Бусад хөрөнгө   | 31,397,480.00          | 108,168,200.00          |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>            | <b>(31,397,480.00)</b> | <b>(108,168,200.00)</b> |
|             | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                                      |                        |                         |
| <b>7</b>    | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                                | <b>-</b>               | <b>-</b>                |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                                      | <b>(0.00)</b>          | <b>-</b>                |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                               | <b>-</b>               | <b>-</b>                |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                              | <b>-</b>               | <b>-</b>                |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн       | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-------------------------|---|
| <b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>       | <b>581,162,917.27</b>           | <b>108,266,082.71</b> | <b>789,969,778.86</b>   | <b>1,479,398,778.84</b>                 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | -                               | -                     | -                       | -                                       |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>581,162,917.27</b>           | <b>108,266,082.71</b> | <b>789,969,778.86</b>   | <b>1,479,398,778.84</b>                 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний                | -                               | -                     | -                       | -                                       |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт        | -                               | -                     | -                       | -                                       |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | -                               | -                     | -                       | -                                       |
| Тайлант үеийн үр дүн                             | -                               | -                     | 826,317,343.07          | 826,317,343.07                          |
| <b>2024 оны 12-р сарын 31-нээрх</b>              | <b>581,162,917.27</b>           | <b>108,266,082.71</b> | <b>1,616,287,121.93</b> | <b>2,305,716,121.91</b>                 |
| <b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>       | <b>581,162,917.27</b>           | <b>108,266,082.71</b> | <b>1,616,287,121.93</b> | <b>2,305,716,121.91</b>                 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | -                               | -                     | -                       | -                                       |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>581,162,917.27</b>           | <b>108,266,082.71</b> | <b>1,616,287,121.93</b> | <b>2,305,716,121.91</b>                 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | -                               | -                     | -                       | -                                       |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  | -                               | -                     | -                       | -                                       |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | -                               | -                     | -                       | -                                       |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               | -                               | -                     | -                       | -                                       |
| Тайлант үеийн үр дүн                             | -                               | -                     | 337,298,664.33          | 337,298,664.33                          |
| <b>2025 оны 12-р сарын 31-нээрх</b>              | <b>581,162,917.27</b>           | <b>108,266,082.71</b> | <b>1,953,585,786.26</b> | <b>2,643,014,786.24</b>                 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт  | Тайлант оны             |                         |
|-----------------------|---|-------------------------|-------------------------|
|                       |   | Батлагдсан төлөвлөгөө   | Гүйцэтгэл               |
| <b>1</b>              | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b> |                         |                         |
| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                | <b>1,047,648,600.00</b> | <b>1,012,704,300.00</b> |
| <b>21</b>             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                    | <b>923,068,600.00</b>   | <b>904,536,100.00</b>   |

Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|             |  |                       |                       |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   | 921,068,600.00        | 860,183,176.43        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                 | 738,054,300.00        | 712,653,539.87        |
| 210101      | Үндсэн цалин   | 401,215,200.00        | 405,479,900.96        |
| 210102      | Нэмэгдэл   | 280,221,000.00        | 262,769,356.00        |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт                                    | 6,336,000.00          | 5,085,000.00          |
| 210104      | Урамшуулал   | 50,282,100.00         | 39,319,282.91         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>    | 92,256,900.00         | 89,233,025.01         |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                       | 62,734,500.00         | 60,756,844.44         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                       | 6,853,400.00          | 6,820,399.03          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 5,008,400.00          | 4,604,940.43          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                     | 2,899,500.00          | 2,882,999.02          |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                    | 14,761,100.00         | 14,167,842.09         |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>         | 16,619,500.00         | 10,233,888.55         |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 5,000,000.00          | 4,337,773.55          |
| 210302      | Түлш, халаалт  | 11,019,500.00         | 5,446,115.00          |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 600,000.00            | 450,000.00            |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                  | 25,985,400.00         | 18,296,840.00         |
| 210401      | Бичиг хэрэг  | 7,973,300.00          | 6,126,600.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 12,600,000.00         | 8,414,340.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                       | 1,044,000.00          | 955,900.00            |
| 210404      | Ном, хэвлэл  |                       |                       |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устга           | 800,000.00            | 800,000.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс              | 3,568,100.00          | 2,000,000.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                 | 7,207,100.00          | 7,269,900.00          |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                  | 2,207,100.00          | 770,000.00            |
| 210604      | Урсгал засвар  | 5,000,000.00          | 6,499,900.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                            | 15,600,000.00         | 11,060,000.00         |
| 210702      | Дотоод албан томилолт                                    | 15,600,000.00         | 11,060,000.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>   | 3,480,200.00          | 1,208,483.00          |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлч            | 2,272,200.00          | 515,383.00            |
| 210803      | Даатгалын үйлчилгээ                                      | 342,300.00            | 342,300.00            |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                               | 224,100.00            | 209,200.00            |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                            | 141,600.00            | 141,600.00            |
| 210807      | Газрын төлбөр  | 500,000.00            | -                     |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                   | 21,865,200.00         | 10,227,500.00         |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 16,493,600.00         | 5,227,500.00          |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                        | 5,371,600.00          | 5,000,000.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | 2,000,000.00          | 44,352,923.57         |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                            | 2,000,000.00          | -                     |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                  | 2,000,000.00          | -                     |
| <b>26</b>   | <b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>                             | -                     | 44,352,923.57         |
| 261090      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                    | -                     | 44,352,923.57         |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                  | <b>124,580,000.00</b> | <b>108,168,200.00</b> |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>                               | 124,580,000.00        | 108,168,200.00        |
| 223001      | Бусад хөрөнгө  | 124,580,000.00        | 108,168,200.00        |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | 1,047,648,600.00      | 1,012,704,300.00      |
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | -                     | -                     |
| <b>1320</b> | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                    | 1,047,648,600.00      | 1,012,704,300.00      |
| 132001      | Орон нутгийн төсвөөс                                     | 1,047,648,600.00      | 1,012,704,300.00      |
| 132004      | Оны эхний үлдэгдэлээс санхүүжих /орон нутаг/             |                       |                       |
| 132007      | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих                  |                       |                       |
| <b>4</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  | -                     | -                     |
| <b>5</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b> | -                     | -                     |
| <b>6</b>    | <b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>                  | -                     | -                     |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                  | -                     | -                     |
| 610001      | Төсвийн байгууллага                                      | 1.00                  | 1.00                  |
| 610002      | Төсвөөс гадуур байгууллага                               |                       |                       |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                  | 24.00                 | 22.00                 |
| 620001      | Удирдах ажилтан  | 2.00                  | 2.00                  |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан  | 18.00                 | 16.00                 |
| 620003      | Үйлчлэх ажилтан  | 4.00                  | 4.00                  |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Завсрын аудитаар нийт 12.5 сая төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэж завсрын аудитын явцад залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

### Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан 10.9 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, “Санхүүгийн тайлангийн толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэж залруулав.
- Цалин нийт зардал, нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлангийн тайлагнасан дүнг 1.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шалгуур журмын 4.1.3-т “Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам болон УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх” 4.1.5.Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх” гэсэнтэй нийцэхгүй байсныг залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 12,783.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 163.2 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөв.

Аудитаар нийт 12.8 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 3.9 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 8.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, өмнөх алдаа зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тайлант жилд ажиллаагүй ажилтнуудад 3.6 сая төгрөгийн цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Нохой устгалын зардлыг гүйцэтгэлээс 0.4 сая төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

## 5.2 Албан шаардлага

1. Нягтлан бодогчид зэрэгцэн хөдөлмөрийн гэрээгээр үндсэн цалинг 100%, бусад

| Алдааны товч утга  | Нийт алдаа |                 | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |                 |              |  |  | Зөвлөмж |     |
|--|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----------------|--------------|--|--|---------|-----|
|  | Тоо        | Дүн             | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн | Залруулсан |                 | Залруулаагүй |  |  | Тоо     | Дүн |
| Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн | 1          | 10,936.0        |                                   |     |                          |     | 1          | 10,936.1        |              |  |  |         |     |
| Цалин, НД, ХХОАТ-ын тайлангийн зөрүү   | 1          | 1,600.9         |                                   |     |                          |     | 1          | 1,600.9         |              |  |  |         |     |
| <b>Дүн</b>   | <b>2</b>   | <b>12,536.9</b> |                                   |     |                          |     | <b>2</b>   | <b>12,536.9</b> |              |  |  |         |     |

холбогдох нэмэгдлүүдийг 7.5 сая төгрөгөөр тооцоолон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д "Ажил олгогч нь ажилтантай тохиролцооноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно", 57 дугаар зүйлийн 57.3-т "Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина", 84 дүгээр зүйлийн 84.4-т "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна" гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Зардлыг анхан шатны баримттай тулгахад шатахууны зардлыг дээд шатны байгууллагаас баталсан жишиг нормтой тулган хяналт хийгээгүй, зардлыг хэтрүүлэн 1.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зам, тээвэр хөгжлийн яамны 2019 оны 390 дүгээр "Жишиг норм батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралт "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-д заасантай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга      | Нийт зөрчил |         | Үүнээс        |         |                 |     |         |     |                                      |     |   |     |  |
|-------------------------|-------------|---------|---------------|---------|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|--|
|                         |             |         | Төлбөрийн акт |         | Албан шаардлага |     | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |  |
|                         | Тоо         | Дүн     | Тоо           | Дүн     | Тоо             | Дүн | Тоо     | Дүн | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |  |
| Тайлант жилд ажиллаагүй | 1           | 3,460.7 | 1             | 3,460.7 |                 |     |         |     |                                      |     |   |     |  |

Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|  |          |                 |          |                |          |                |  |  |  |  |  |  |
|--|----------|-----------------|----------|----------------|----------|----------------|--|--|--|--|--|--|
| ажилтнуудад цалин олгосон  |          |                 |          |                |          |                |  |  |  |  |  |  |
| Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг олгосон  | 1        | 426.4           | 1        | 426.4          |          |                |  |  |  |  |  |  |
| Нягтлан бодогчид зэрэгцэн хөдөлмөрийн гэрээгээр үндсэн цалинг 100%, бусад холбогдох нэмэгдлүүдийг тооцоолон олгосон  | 1        | 7,483.2         |          |                | 1        | 7,483.2        |  |  |  |  |  |  |
| Зардлыг анхан шатны баримттай тулгахад шатахууны зардлыг дээд шатны байгууллагаас баталсан жишиг нормтой тулган хяналт хийгээгүй, зардлыг хэтрүүлэн зарцуулсан | 1        | 1,412.8         |          |                | 1        | 1,412.8        |  |  |  |  |  |  |
| <b>Дүн</b>   | <b>4</b> | <b>12,783.1</b> | <b>2</b> | <b>3,887.1</b> | <b>2</b> | <b>8,896.0</b> |  |  |  |  |  |  |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                  | Үүнээс        |     |                 |                  |          |     |
|--|-------------|------------------|---------------|-----|-----------------|------------------|----------|-----|
|  |             |                  | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                  | Зөвлөмж  |     |
|  | Тоо         | Дүн              | Тоо           | Дүн | Тоо             | Дүн              | Тоо      | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил   |             |                  |               |     |                 |                  |          |     |
| Тайлант хугацаанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаа хоцорч мэдээлсэн 10, 2 мэдээг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 658.8 сая төгрөгийн 9 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй байна. | 1           | 171,465.7        |               |     | 1               | 171,465.7        |          |     |
| Тайлант хугацаанд УИХ-ын 2025 оны 48 дугаар тогтоолоор "...багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах..." арга хэмжээг авч ажиллаагүй байна.   | 1           |                  |               |     |                 |                  | 1        |     |
| Ажиллаагүй ажилтанд цалин хөлс тооцон олгосон зөрчлийг давтан гаргасан тул албан тушаалтанд хариуцлага тооцох  | 1           |                  |               |     | 1               |                  |          |     |
| <b>Нийт дүн</b>  | <b>3</b>    | <b>171,465.7</b> |               |     | <b>2</b>        | <b>171,465.7</b> | <b>1</b> |     |